



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 1/36

Хажуу шинэ ус

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Улсын онцгой комиссын 2022 оны 02 дугаар тогтоол, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/77 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын А/174 тоот захирамж, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/77 дугаар тушаалын дагуу 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд үхэр сүргийг гоц халдварт шүлхий өвчний дархлаажуулалтад бүрэн хамруулахыг "Угтаал чандмань" хоршоо Мал эмнэлэг үйлчилгээний нэгжийн малын эмч (Д.Амгалан)-д үүрэг болгосугай.

2. Малчид, мал бүхий иргэдэд тов хүргэж, зарлан мэдээлэх ажлыг Ажирхай багийн Засаг дарга (Б.Мөнхтөгөлдөр), Морьт багийн Засаг дарга (Г.Батчулуун), Хонгор багийн Засаг дарга (Б.Наранбаатар) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.МӨНХ-АМГАЛАН